

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-07-07

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 07 дугаар сарын 18-ны “Баасан” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.
- 8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
- 8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
- 8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
- 8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Баяр, амралтын өдрүүдэд хөрөнгө оруулалтын ажлыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.	СТСХ, ХААА Ашиглагч байгууллагууд
2	Дүүргийн хэмжээнд худалдан авах ажиллагааны явц, үр дүнгээр танилцуулга бэлтгэж, олон нийтэд танилцуулах.	СТСХ, ХААА
3	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг газар дээр нь очиж шалган, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
4	Дүүргүүд хот нийтийн аж ахуйн эрх шилжүүлж авсан ажлуудаа эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Хороод
5	Явган хүний замын тохижилтын ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, холбогдох байгууллагууд засвар, тохижилтын ажлаа шуурхай гүйцэтгэж, дуусгах.	ЗДО Х.Цогцэцэг, Ажлын хэсгүүд, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
7	Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, урьдчилан сэргийлэх.	ТХҮХ
8	Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, иргэд болон байгууллагыг ус, цахилгаан хангамжаар тасалдуулахгүй байхад анхаарч, бэлэн байдлыг хангах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
9	Баяр наадмын өдрүүдэд үер ус, гамшиг осол, гал түймрийн аюул болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг эрчимжүүлэх.	ОБХ, ЦХ, Нийт байгууллагууд
10	Баяр наадмын өдрүүдэд байгууллагууд хариуцлагатай жижүүр ажиллуулах.	ОБХ, Нийт байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
11	“Эрүүл мэндийн төв”-ийн нөөц цахилгаан үүсгүүрийн талаар судалж танилцуулах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж
12	Соёлын ордны барилгын ажлын гүйцэтгэгч ХХК-тай байгуулсан гэрээг шуурхай цуцалж, дараагийн гүйцэтгэгчийг яаралтай сонгон шалгаруулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ЗДО Х.Цогцэцэг
13	Дархлаажуулалтад хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж, эрчимжүүлэх.	НХХ, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төв, ЕБС, СӨББ-ууд
14	Боловсролын сайдаас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр дүүргийн Засаг даргад хандан ирүүлсэн 1/2944 дүгээр албан бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2025-2026 оны	НХХ, Боловсролын хэлтэс, СӨББ-ууд

	хичээлийн жилд 5 настай хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах, өнгөрсөн хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадаагүй 5 настнуудын шалтгаан нөхцөлийг судалж тодруулах.	
ДҮҮРГИЙН МЕНЕЖЕРЭЭС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
15	Инженерийн хангамжийн байгууллагууд баяр наадмын үеэр хариуцлагатай эргүүл, жижүүр томилж, үүссэн нөхцөл, авсан арга хэмжээний мэдээллийг шуурхай солилцож тайлан мэдээг 2025 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 15:00 цагаас өмнө холбогдох газарт хүргүүлэх.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
16	Баяр наадмаас өмнө гэрэлтүүлгийн байгууламж болон гэрлэн чимэглэлүүдэд үзлэг шалгалтыг зохион байгуулж, хэвийн, найдвартай ажиллагааг хангах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
17	Баяр наадмаас өмнө бут, сөөгийг хэлбэржүүлж, ургамлын өвчин, хортонтой тэмцэх ажлыг эрчимжүүлэх.	

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР